

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

(2025 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар)

1. Ерөнхий мэдээлэл

“Эм Жи Эл Акуа” ХК нь IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ашиглахаар төлөвлөсөн.

2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нийт 15,234,677,184 (арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун наяд дөрвөн) төгрөгийг IPO-оор амжилттай татан төвлөрүүлж, компанийн банкны дансанд хүлээн авсан болно.

2. Хөрөнгийн зарцуулалт

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдлаар хийгдсэн байна.


2.1. Түүхий эд, материалын худалдан авалт

IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,116,812,809 төгрөгийг түүхий эд, материал (ТЭМ) худалдан авахад зарцуулсан бөгөөд уг зардлыг 2024 онд бүрэн санхүүжүүлж дуусгасан.

2.2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн худалдан авалт

2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам худалдан авахад 4,500,000,000 төгрөг, трансформатор худалдан авахад 550,000,000 төгрөг тус тус зарцуулсан (Зураг 1).

Зураг 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө



Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эхний багц болох цэвэршүүлэх (филтер) шугамыг 2025 оны 5 дугаар сарын 3-наас 5 дугаар сарын 23-ны хооронд суурилуулсан. Үйлдвэрийн зуны оргил ачааллын үе дууссаны дараагаар үлдсэн тоног төхөөрөмжийг 2025 оны 11 дүгээр сар гэхэд бүрэн суурилуулж дуусгахаар төлөвлөж байна.

2.3. Орон нутгийн үйлдвэрийн төсөл

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр байгуулах төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн.

1. Өмнөговь аймагт газар худалдан авч, Эм жи эл акуа ХК-ийн охин компанийг байгуулсан.
2. Үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

2025 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар орон нутгийн үйлдвэрийн төсөлд IPO-оос татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6,067,863,875 төгрөг, компанийн өөрийн орлогоос 70,138,125 төгрөг тус тус зарцуулсан байна.

3. IPO хөрөнгийн зарцуулалттай холбоотой хугацаа хойшлох шалтгаан

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр барих төсөл нь анхны төлөвлөгөөний дагуу 2025 оны эхний хагаст ашиглалтад орохоор тусгагдсан байсан ч дараах бодит шалтгаануудын улмаас хэрэгжилтийн хугацаа хойшлогдсон. Үүнд:

3.1. Усны нөөцийн хайгуулын хугацаа урт сунжирсан

Өмнөговь аймагт усны геофизикийн болон гидрогеологийн хайгуулын судалгаанууд нь олон үе шаттай, цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд зөвшөөрөл олголт, үр дүнг баталгаажуулах ажиллагаа хойшилсон.

3.2. Байгаль орчны үнэлгээтэй холбоотой шаардлагууд

Усны хайгуулын дараах байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх үйл явц нь урьдчилан тооцоолсноос удааширсан.

3.3. Зураг төсөл, тендер шалгаруулалтын хугацаа

Үйлдвэрийн барилга, дэд бүтцийн зураг төслийг батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа цаг хугацаа авч, графикаас хоцорсон.

3.4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах, зөвшөөрөл авах үе шат удааширсан

Төсөлтэй холбоотой зөвшөөрөл, дэмжлэгийг орон нутгийн байгууллагуудаас авах явцад тодорхой хугацааны зөрүү гарсан.

Одоогоор төслийн хэрэгжилт шинэчлэгдсэн графикайн дагуу хэвийн үргэлжилж байна.